



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

“Улсын байцаагчийн урамшуулал
олгох журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг хангах зорилгоор “Улсын байцаагчийн урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулж Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын байцаагчийн эрхтэй хянан шалгагчдад олгох урамшуулал, түүнийг олгох журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000793

УЛСЫН БАЙЦААГЧИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

УХА0410 5043239

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны Улсын байцаагч /цаашид “Байцаагч” гэх/-ийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байх, үүрэгт ажлаа үр дүнтэй, тасралтгүй явуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор эдийн засгийн баталгаагаар хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, тэдгээртэй холбогдон гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон “Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам”, “Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн дүрэм”-тэй нийцсэн байна.

1.3. “Улсын байцаагчийн урамшуулал” гэж энэхүү журмын 2.3, 2.4-д заасан аргачлалаар тооцож, хяналт шалгалтын чиг үүрийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах зорилгоор Улсын байцаагчид олгох онцгой нэмэгдлийг ойлгоно.

Хоёр. Улсын байцаагчийн урамшуулал олгох

2.1. Байцаагч нь холбогдох хуулиуд болон “Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам”-д заасан цалин хөлс, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр тэтгэмжээс гадна Улсын байцаагчийн урамшуулал авна.

2.2. Улсын ахлах байцаагч, байцаагчид олгох урамшууллыг хорооны Улсын ерөнхий байцаагч тогтооно.

2.3. Улсын ерөнхий байцаагчийн урамшууллыг сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцож, сар бүр олгоно. Ахлах байцаагчид олгох урамшууллыг үндсэн цалингийн 30 хүртэл хувиар сар бүр дараах байдлаар тооцож олгоно:

Тогтмол олгох хувь	15%
Улсын байцаагчийн тавьсан захиргааны акттай холбогдуулж гаргасан гомдлыг шийдвэрлэсэн болон хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцсон байдал	15% хүртэл

2.4. Байцаагчийн урамшууллыг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хүртэл хувиар тооцож сар бүр олгох бөгөөд холбогдох хууль болон “Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн дүрэм”-д заасан үүргээ биелүүлсэн байдал, байцаагчаар ажилласан жил, харьяалах газар, хэлтсийн дарга, харьяалах дээд албан тушаалтны өгсөн үнэлгээг харгалзан дараах байдлаар тооцож олгоно:

<i>Улсын байцаагчаар ажилласан жил</i>		<i>Даргын үнэлгээ</i>
80 %		20%
4 хүртэл жил	60 %*	
5-9 жил хүртэл	80 %*	
10 жил болон түүнээс дээш	100 %*	

*80%-иас тооцох хувь хэмжээ

Дээрх үзүүлэлтийн жигнэсэн дундаж хувь ба нэмэгдэл олгох хувийг дараах байдлаар тооцно:

<i>Жигнэсэн дундаж</i>	<i>Нэмэгдэл олгох хувь</i>
50-60 %	10%
61-70 %	15%
71-80 %	20%
81-90 %	25%
91-100 %	30%

2.5. Байцаагчийн урамшууллыг энэхүү журмын нэгдүгээр хавсралтад зааснаар Ахлах байцаагчийн урамшууллыг энэхүү журмын хоёрдугаар хавсралтад зааснаар тус тус дүгнэж олгоно.

Гурав. Бусад


3.1. Улсын байцаагчид хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд хот суурингийн доторх нийтийн тээврийн хэрэгслээр зорчиход зориулж 20,000 төгрөгийг сар бүр тогтмол олгоно.

3.2. Улсын байцаагч газар дээр хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ албаны унаагаар үйлчлүүлэх эрхтэй.

3.3. Улсын байцаагчид олгох нэмэгдлийг энэ журмын 2.3, 2.4-т заасны дагуу жилд 2 удаа /хагас, бүтэн жилийн тайлант хугацаанд/ Улсын байцаагчийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

-----ooOoo-----

“Улсын байцаагчийн урамшуулал олгох журам”-ын нэгдүгээр хавсралт



УЛСЫН БАЙЦААГЧИД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

.....
/газар, хэлтэс, албаны нэр/

.....
/Байцаагчийн овог, нэр/

Улсын байцаагчаар ажилласан жил	Эзлэх хувь 80 %		
	дүгнэх хувь	ажилласан жил	Үнэлэх хувь
4 жил хүртэл	60%		48 %
5-9 жил хүртэл	80%		64 %
10 болон түүнээс дээш жил	100%		80 %
Газар, хэлтсийн даргын үнэлгээ	Эзлэх хувь 20%		
	дүгнэх хувь	үнэлсэн хувь	гарын үсэг
ур чадвар	10 % хүртэл		
ажлын биелэлт /хугацаа/	5 % хүртэл		
ёс зүй	5 % хүртэл		
НИЙТ			
Жигнэсэн дундаж			√
50-60 %		10%	
61-70 %		15%	
71-80 %		20%	
81-90 %		25%	
91-100 %		30%	
Эцсийн үнэлгээ		Гарын үсэг	
Дүгнэсэн:..... / харьяалах газар, хэлтсийн дарга, харьяалах дээд албан тушаалтан//овог, нэр, тэмдэг/		/огноо/	
Танилцсан: Улсын байцаагч/овог, нэр/		/огноо/	
Танилцсан: Улсын ерөнхий байцаагч:/овог, нэр, тэмдэг/		/огноо/	

“Улсын байцаагчийн урамшуулал
олгох журам”-ын хоёрдугаар хавсралт



**УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИД УРАМШУУЛАЛ ОЛГОХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

.....
/Ахлах байцаагчийн овог, нэр, тэмдэг/

Нийт нэмэгдэл олгох хувь хэмжээ	30 %
Тогтмол олгох хувь	15%
Улсын байцаагчийн тавьсан захиргааны акттай холбогдуулж гаргасан гомдлыг шийдвэрлэсэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцсон байдал	15% хүртэл
Эцсийн үнэлгээ	
Дүгнэсэн:...../Улсын ерөнхий байцаагч/	/огноо/
Танилцсан: Улсын ахлах байцаагч/овог, нэр/	/огноо/

-----ooOoo-----